



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/182

Чойр

Цагийн хязгаарыг шинэчлэн  
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, 66.2, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.1, 16.2.2, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 23 дугаар зүйлийн 23.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11, 28.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цагийн хязгаарыг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.


2. Монгол улсын Ерөнхийлөгчийн болон Монгол улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах өдөр, санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөр 04 дүгээр сарын 07, Эх үрсийн баярын өдөр 06 дугаар сарын 01, Хичээлийн шинэ жил 09 дүгээр сарын 01, сар бүрийн 25-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхийг тус тус хориглосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Э.Түвшинзаяа), Эрүүл мэндийн газрын дарга (Ц.Мөнх-Од), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Хонгор) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг)-д даалгасугай.

5. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн "Худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоох тухай" 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/18 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400199

Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 сарын 27 өдрийн 2/2 дугаар  
захирамжийн хавсралт

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ  
эрхлэх цагийн хязгаар

№	Худалдаа үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Эхлэх	Дуусах
Аймгийн хэмжээнд				
1	Тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүр, хайпермаркет, супермаркет, минимаркет, ая тухтай дэлгүүр	Архи согтууруулах ундаа худалдах	08:00	23:00
2	Бөөний худалдааны төв	Архи согтууруулах ундаа худалдах	08:00	22:00
3	Ресторан, кафе	Архи согтууруулах ундаагаар үйлчлэх	11:00	22:00
4	Баар, лоунж	Архи согтууруулах ундаагаар үйлчлэх	14:00	02:00
5	Караоке	Архи согтууруулах ундаагаар үйлчлэх	14:00	00:00
5	Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	Архи согтууруулах ундаагаар үйлчлэх	14:00	00:00